БАТЛАВ.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Л. ОЮУНЖАРГАЛ

САНХҮҮГИЙН ЦАХИМ ПРОГРАМ ЗОХИОН, НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

1	Үндэслэл	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээний цахим шилжилттэй холбогдуулан Цаг уур, орчны шинжилгээний салбарын үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт технологи бүхий санхүүгийн цахим програмыг нэвтрүүлэх
2	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	ЦУОШГ-ын 2023 оны урсгал төсвөөс
3	Санхүүжилтийн хуваарь	Үнийн дүн 39,000,000 /гучин есөн сая/ төгрөг Ажлыг хүлээн авсны дараа санхүүжилтийг 100 хувь олгоно.
4	Захиалагч байгууллага	Цаг уур, орчны шинжилгээний газар
5	Ажлын зорилго	Санхүүгийн бүртгэлийн нэгдсэн системийн програм хангамжийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн тайлагналын Улсын секторын нягтлан бүртгэлийн олон улсын стандарт, заавар журамд нийцүүлэн нэгтгэн боловсруулж тайлагнах;
6	Гүйцэтгэх ажлууд	• Санхүүгийн цахим програм хангамж нь Сангийн яамнаас тусгай зөвшөөрөлтэй байх; • Нягтлан бодох бүртгэлийн програм нь санхүүгийн тайлангийн нэгтгэл хийдэг, холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн тайлагналын Улсын секторын нягтлан бүртгэлийн олон улсын стандарт болон бусад заавар журамд нийцсэн байх; • Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ нэгтгэдэг байх; • Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэрийг иж бүрнээр (анхан шатны баримтын мэдээлэл, дансны бичилтийн мэдээлэл) тодорхой харуулдаг байх; • Ашиглахад энгийн ойлгомжтой, тайлбар танилцуулга, гарын авлагатай байх ба бусад үйлдлийн системтэй холбогдох талаар уян байх;

		• Програм хангамж нь нууцлал, багтаамж өндөр, ачаалал даах технологиудаар хөгжүүлэгдсэн байх; • Програм хангамж нь цахим орчинд ажиллах технологид суурилагдсан байх; • Нэгдсэн өгөгдлийн санд мэдээлэл бүртгэгдэж, мэдээллийн давхардал үүсэхээс сэргийлж, мэдээлэл цэгцтэй, үнэн зөв байх нөхцөл бүрдүүлэх; • Санхүүгийн мэдээлэл нь серверийн хамгаалалттай орчинд байрлаж мэдээллийн аюулгүй байдал бүрэн хангагдсан байх; • Харьяа байгууллагуудын мөнгөн хөрөнгө болон үндсэн хөрөнгө бараа материал, авлага, өглөгийн байгууллага тус бүрээр харж хянадаг байх; • Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, тайлан, бараа материал, үндсэн хөрөнгийн ангиллыг харьяа байгууллага болон салбарын хэмжээнд нэгтгэсэн байдлаар гаргах боломжтой байх; • Салбар харьяа байгууллага хооронд санхүүжилт, бараа материал, үндсэн хөрөнгийн гүйлгээг шилжүүлэх хүлээн авах боломжоор хангагдсан байх; (Гүйлгээ шилжилтийн давхар бүртгэл хийгдэхгүй) • Хэрэглэгчийн хийх үйлдлийг ерөнхий нягтлан, тооцооны нягтлан зэрэг ангилал үүсгэн модуль болон програмын дэлгэцүүдийг хуваарилах, мөн үйлдэл хийх эрхийг (нэмэх, хасах, хэвлэх) заахаас гадна ямар дансад гүйлгээ хийх боломжтойг тохируулан хязгаарлах; • Ажилтаны цалингаас суутгах ХХОАТ, НДШ-ийн тайланг цахим хуудасд хүн тус бүрээр татдаг байх; • Санхүүгийн болон төсвийн тайлангийн бариаг шалгах, гүйлгээ болон тайлан гаргахад бусад мэдээлэл бүртгэлийн хувьд хангагдсан эсэхийг шалгаж алдааг шалгадаг байх; • Санхүүгийн болон төсвийн тайлан мэдээг Э-Тайлан, Татвар, Нийгмийн даатгал, Шилэн данс, Үндэсний аудитын газрын стаус програм болон бусад холбогдох системүүдийг илгээдэг байх;

		• Эд хариуцагчийн хөрөнгийг QrCode хэвлэн бүртгэлжүүлж нярав, эд хариуцагчийн тооллого хийхдээ QrCode уншигч утасгүй төхөөрөмж ашиглан автоматаар тоолох; • Гүйлгээний хялбаршуулсан загвар үүсгэн ашиглах боломжтой байх; • Гүйлгээг хугацаа тохируулан түгжих; • Төсвийн байгууллагад нэвтрүүлээд 2-3 жилийн хугацаанд туршигдсан байх; • 26 хэрэглэгчдийн худалдан авах үнэ, цаашид ашиглалтын хугацаанд төлөх төлбөрийн хэмжээ, дуудлагын болон засвар үйлчилгээний үнэ, сургалт хийх хуваарь ирүүлэх; • Төрийн сангийн төлбөр тооцооны портал системтэй холбогдож тухайн өдрийн гүйлгээнүүдийг татаж нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх; • Үндсэн хөрөнгийн дансны үнэ “0” болсон тохиолдолд дахин үнэлгээ хийхэд анх ашиглалтанд орсон жил, анхны өртгийг зэрэгцүүлж харах боломжтой байх; • Нягтлан, нярав нар ажил гүйлгээгээ өөрсдийн ажил үүргийн хуваарийн дагуу тус тусдаа бүртгэж, ажил гүйлгээгээ дор бүр нь хянан алдаагаа олох боломжтой байх; • Гар утас, таблет дээр тайлан харахад филтер хийх боломжтой байх; • Төлбөр төлөх хугацааны мэдээлэл гарч авлагын насжилтын тайлан боловсруулдаг байх; • Сангийн яам, Аудит болон татвар, нийгмийн даатгалын заавар журам, Э-тайлан гэх мэт тайлан маягтуудын дагуу бүртгэлээ хөтөлж тайлангуудаа авдаг хөрвүүлдэг байх; • Балансын эхний үлдэгдэл, бараа материалын код, бар код, үлдэгдлийн мэдээлэл, үндсэн хөрөнгийн кодын болон эхний үлдэгдлийн мэдээллийг Excel программаас татан оруулах боломжтой байх; • Тайлангийн иж бүрдэл дэд системтэй байх. (Батлагдсан маягтын дагуу) • Тайлангууд дээр DnII Down тайлан буюу тайлангийн бүх үзүүлэлтийг хаанаас ямар үндэслэлээр гарч ирснийг задалж үзэх боломжийг оруулж өгдөг байх;

		• Excel, Word, XML, HTML, PDF программуудтай холбогдон мэдээлэл гаргах, татаж авах боломжтой байх; • Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан гаргах ТӨ, ТӨХ маягтуудыг нэгтгэлээр гаргах; • Шүүлтийн уян хатан нөхцөлүүдийг ашиглан хүссэн баримт, гүйлгээгээ хянадаг байх; • Үүссэн нэхэмжлэх татварын сайт руу хөрвөдөг байх; • Гүйлгээг хугацаа тохируулан түгжих; • Урьд онуудын санхүүгийн тайлангийн бааз, үлдэгдлийг автоматаар хуулж хадгалдаг байх;
7	Нийлүүлэгчид тавигдах шаардлага	- Төсөвт байгууллагад ашиглах боломжтой нягтлан бодох бүртгэлийн програм хангамж зохиох тусгай зөвшөөрөлтэй байх; - Санхүүгийн програм зохион нийлүүлэх мэргэшсэн багаас бүрдсэн, хүний нөөц, материаллаг баазтай хуулийн этгээд байх;
8	Ашиглах материал	1. Монгол Улсын хуулиуд - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль - Төсвийн тухай хууль - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
9	Баримт бичгийн иж бүрдэл	Тайлангийн иж бүрдэл: - Санхүүгийн цахим програм -26 ширхэг - Санхүүгийн програм ашиглах заавар, бусад холбогдох материалыг-Хэвлэмэл болон цахим хэлбэрээр 26 ширхэг Програм, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх хугацаа: -Гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор санхүүгийн цахим програм, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгнө.
10	Төрийн нууцыг хадгалах хамгаалах	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, задруулахгүй байх асуудлыг холбогдох хууль, журмаар зохицуулна.

ХЯНАСАН:

СТХАХ-ИЙН ДАРГА Н. ГАЛЦОГ

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ Д. ОТГОНБАЯР